



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/53/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг , Сайншанд сум 2019 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469      Цахим хаяг: ..... Аудитын менежер: Э.Энхцэцэг Утас: 90077079      Цахим хаяг: ..... Аудитор:              Э.Батчимэг Утас: 99032916      Цахим хаяг: .....</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
Дорноговь аймаг , Төрийн аудитын газар , Сайншанд сум , Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13

## 1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншянд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019.02.26 № 1-6/221

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.


**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч А.Ариунаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 24-наас 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар 2019 оны 2 дугаар сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэг нь Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах , хамгаалах , хөгжүүлэх , сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэргэжилтэн Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны *Нийт зардал* 211,172.1 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 525.29 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	43,137.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	43,137.00	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 191,677.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 191,677.4 мянган төгрөг буюу 100 хувьтай төсөвт хэтрэлт хэмнэлт гараагүй байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Д.Чулуунбаатараас 200000 төгрөгийн авлагатай бөгөөд тус ажилтан ажлаас халагдсан эргэн төлөх эсэх нь тодорхойгүй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
2. 2018 оны 12-р сарын 31-ний байдлаар 621125 төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна
3. Засгийн газраас баталсан журмын дагуу 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Ахмадын санд 802237 төгрөг шилжүүлсэн бөгөөд ямар нэг үйл ажиллагаанд зарцуулагдаагүй цалингийн санд зардлаар тооцсон байна.
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт эд хариуцагч материалын төрөл тус бүрээр агуулахын бүртгэл хөтөлж тайлант хугацааны эцэст хариуцсан нягтлан бодогчид бараа материалын нэр төрлийн болон үнийн дүнгийн тайлан гаргахаар заасан боловч тус цэцэрлэг 2018 оны жилийн эцсийн байдлаар бараа материалын нэр төрөл, үнийн дүнгийн тайлан гаргаагүй нийт дүнгээр тайлагнасан байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

#### 3.1.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Д.Чулуунбаатараас 200000 төгрөгийн авлагатай бөгөөд тус ажилтан ажлаас халагдсан эргэн төлөх эсэх нь тодорхойгүй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх , эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалт , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 заалтуудыг тус тус мөрдөж ажиллах

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

#### 3.2.1 Илрүүлэлт:

2018 оны 12-р сарын 31-ний байдлаар 621125 төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Авлага өглөгийг барагдуулж ажиллаагүй байх

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг мөрдөж , өр авлага гаргахгүй ажиллах

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

### **3.3 Зардлын данстай холбоотой асуудал**

#### 3.3.1 Илрүүлэлт:

Засгийн газраас баталсан журмын дагуу 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Ахмадын санд 802237 төгрөг шилжүүлсэн бөгөөд ямар нэг үйл ажиллагаанд зарцуулагдаагүй цалингийн санд зардлаар тооцсон байна.

Энэ нь эрх ба үүрэг , бодитой оршин байх ба тохиолдсон байх , үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

#### 3.3.2 Эрсдэл:

Хууль дүрэм журам зөрчигдсөн байх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Ахмадын сан байгуулж ажиллах журамд сангийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд хэрхэн бүртгэх , зарцуулагдаагүй үлдэгдлийг хэрхэн тайлагнах талаар тодорхой тусгах нь зүйтэй байна.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

## 3.4 Балансын данстай холбоотой асуудал

### 3.4.1 Илрүүлэлт:

Боловсрол , соёл , шинжлэх ухаан , спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт эд хариуцагч материалын төрөл тус бүрээр агуулахын бүртгэл хөтөлж тайлант хугацааны эцэст хариуцсан нягтлан бодогчид бараа материалын нэр төрлийн болон үнийн дүнгийн тайлан гаргахаар заасан боловч тус цэцэрлэг 2018 оны жилийн эцсийн байдлаар бараа материалын нэр төрөл , үнийн дүнгийн тайлан гаргаагүй нийт дүнгээр тайлагнасан байна.

Энэ нь эрх ба үүрэг , иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар , НБББББичгийг тус тус зөрчсөн байна.

### 3.4.2 Эрсдэл:

Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргадаггүй байх

### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар , Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах , бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

---

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

	Үзүүдэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,129,400.22	41,713,696.22
2	МӨНГӨ БА ТҮҮНГЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	(0.00)	0.00
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	(0.00)	0.00
9	Төгрөг	(0.00)	0.00
10	Төрийн сангийн харилцах	(0.00)	0.00
27	АВЛАГА	1,069,400.00	200,000.00
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	200,000.00	200,000.00
34	Бусад авлага	869,400.00	-
35	Байгууллагаас авах авлага	461,340.00	-
36	Хувь хүмүүсээс авах авлага	408,060.00	-
60	БАРАА МАТЕРИАЛ	32,060,000.22	41,513,696.22
61	Түүхий эд материал	6,207,353.72	6,207,353.72
62	Тусгай зориулалттай материал	6,207,353.72	6,207,353.72
66	Хангамжийн материал	25,852,646.50	35,306,342.50
67	Бичиг хэргийн материал	143,000.00	865,750.00
68	Аж ахуйн материал	22,941,809.50	30,470,505.50
72	Хүнсний материал	1,740,700.00	2,834,450.00
73	Бусад хангамжийн материал	1,027,137.00	1,135,637.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	797,646,402.33	782,264,892.45
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	797,646,402.33	782,264,892.45
108	Биет хөрөнгө	797,646,402.33	775,264,892.45
109	Барилга, байгууламж	822,287,845.00	780,930,495.00
110	Хуримтлагдсан элэгдэл	(65,845,891.16)	(37,657,982.32)
113	Машин, тоног төхөөрөмж	36,112,728.00	37,012,728.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(17,252,664.15)	(23,726,770.82)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,002,386.52	29,002,386.52
116	Хуримтлагдсан элэгдэл	(12,183,060.84)	(14,622,869.33)
122	Бусад үндсэн хөрөнгө	9,390,768.00	9,390,768.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(4,198,769.04)	(5,396,922.60)
125	Номын фонд	333,060.00	333,060.00
126	Биет бус хөрөнгө	-	7,000,000.00
129	Бусад биет бус хөрөнгө	-	7,000,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	830,775,802.55	823,978,588.67
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,346,450.00	621,125.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,346,450.00	621,125.00
164	Өглөг	1,346,450.00	621,125.00
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	1,324,800.00	192,545.00
166	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	214,090.00
170	Бусад өглөг	21,650.00	214,490.00
171	Байгууллагад төлөх өглөг	21,650.00	-
172	Хувь хүмүүст төлөх өглөг	-	214,490.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	829,429,352.55	823,357,463.67
215	Засгийн газрын хувь оролцоо	829,429,352.55	823,357,463.67
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	778,772,800.44	785,772,800.44
217	Өмч: -Төрийн өмч	778,772,800.44	785,772,800.44
223	Хуримтлагдсан үр дүн	(6,679,536.69)	37,584,663.23
224	Өмнөх үеийн үр дүн	(6,679,536.69)	50,656,552.11
225	Тайлант үеийн үр дүн	-	(13,071,888.88)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,336,088.80	-
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	830,775,802.55	823,978,588.67

4417144353  
EHOA0056 9025707

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	210,880,329.50	249,573,250.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,784,829.50	57,895,850.00
77	Нийтлэг татварын бус орлого	18,784,829.50	57,895,850.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	18,784,829.50	57,895,850.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,784,829.50	57,895,850.00
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	192,095,500.00	191,677,400.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	217,559,866.19	211,172,082.25
148	УРСГАЛ ЗАРДАЛ	217,559,866.19	211,172,082.25
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194,251,581.68	200,687,854.36
150	Цалин, хөлө болон нэмэгдэл урамшил	96,228,208.74	103,187,876.52
151	Цалин	96,228,208.74	90,559,676.85
152	Нэмэгдэл цалин	-	5,098,199.67
154	Урамшуулал	-	7,530,000.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,118,892.75	11,935,199.59
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,277,154.75	8,053,099.59
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	960,434.00	970,500.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	768,347.00	776,400.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	192,087.00	194,100.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,920,870.00	1,941,100.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,803,842.00	26,943,861.00
165	Гэрэл цахилгааны зардал	2,024,057.00	2,247,952.00
166	Түлш, халаалтын зардал	20,770,000.00	22,107,948.00
167	Цэвэр, бохир усны зардал	3,009,785.00	2,587,961.00
170	Хангамж, бариа материалын зардал	3,304,898.00	2,494,874.00
171	Бичиг хэргийн материал	1,021,000.00	346,890.00
172	Тээвэр, шатахууны зардал	525,130.00	470,340.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	466,468.00	264,120.00
174	Ном, хэвлэлийн зардал	7,500.00	21,500.00
175	Хөг хаягдал устгах, цэвэрлэх	-	5,000.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,284,800.00	1,387,024.00
181	Нормативт зардал	25,850,310.00	25,594,920.00
182	Эм	72,250.00	83,380.00
183	Хоол	25,778,060.00	25,511,540.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,137,500.00	304,800.00
189	Урсгал засвар	1,137,500.00	304,800.00
190	Томилголт, зочны зардал	107,800.00	150,000.00
192	Дотоод томилголын зардал	107,800.00	150,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	275,440.00	330,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271,440.00	330,000.00
203	Улсын мэдээллийн маягтын зардал	4,000.00	-
209	Бариа үйлчилгээний бусад зардал	30,424,690.19	29,746,323.25
211	Хячээл сургалт, үйлдвэрлэлийн дасгалын зардал	362,500.00	42,020.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	30,062,190.19	29,704,303.25
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,308,284.51	10,484,227.89
228	Бусад урсгал шилжүүлэг	19,717,600.00	10,163,400.00
234	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,417,600.00	-
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжл	-	10,163,400.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,300,000.00	-
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,590,684.51	320,827.89
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,590,684.51	320,827.89
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(6,679,536.69)	38,401,167.75
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	51,473,056.63
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	51,473,056.63
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI-IV-V)	-	(51,473,056.63)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(6,679,536.69)	(13,071,888.88)

4417144353  
ЕНОА0066 9025707

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр

	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	192,095,500.00	191,677,400.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	192,095,500.00	191,677,400.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	192,095,500.00	191,677,400.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	189,040,500.00	190,777,400.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	189,040,500.00	190,777,400.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	165,732,215.49	180,293,172.11
150	Цалин, хөлө болон нэмэгдэл урамшил	96,326,920.74	103,643,276.52
151	Үндсэн цалин	84,762,206.21	91,015,076.85
152	Нэмэгдэл	4,034,715.00	5,098,199.67
154	Үр дүнгийн урамшуулал	7,529,999.53	7,530,000.00
157	Ажил олгочоос нийгтийн давтгалд төлөх шимтгэл	10,564,780.75	11,935,199.59
158	Тэтгэврийн давтгалын шимтгэл	6,723,042.75	8,053,099.59
159	Тэтгэмжийн давтгалын шимтгэл	960,434.00	970,500.00
160	ҮОМШ өвчний давтгалын шимтгэл	768,347.00	776,400.00
161	Ажилгүйдлийн давтгалын шимтгэл	192,087.00	194,100.00
162	Эрүүл мэндийн давтгалын хураамж	1,920,870.00	1,941,100.00
164	Байр шингэлтэй холбоотой тогтмол зардал	25,954,842.00	27,072,961.00
165	Гэрэл цахилгааны зардал	2,049,057.00	2,247,952.00
166	Түлш, халшлын зардал	20,770,000.00	21,960,900.00
167	Цэвэр, бохир усны зардал	3,135,785.00	2,864,109.00
170	Хангамж, бараа материалын зардал	6,500,626.00	1,987,670.00
171	Бичиг хэрэг	119,250.00	318,200.00
172	Тээвэр, шатахуун	525,130.00	528,930.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	93,982.00	114,080.00
174	Ном, хэвлэл	40,500.00	130,000.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,721,764.00	896,460.00
181	Норматив зардал	24,715,520.00	28,586,175.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,200.00	48,200.00
183	Хоол, хүнс	24,674,320.00	26,221,975.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,316,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	140,000.00	4,836,180.00
189	Урсгал засвар	140,000.00	4,836,180.00
190	Томилуулт, зочны зардал	79,800.00	150,000.00
192	Дотоод албан томилуулт	79,800.00	150,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	472,520.00	482,540.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	472,520.00	482,540.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	977,206.00	1,599,170.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	977,206.00	1,599,170.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,308,284.51	10,484,227.89
225	Бусад урсгал шилжүүлэг	19,717,600.00	10,163,400.00
231	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,417,600.00	-
232	Хөдөө орон нутагт төгвөртэй ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	-	10,163,400.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,300,000.00	-
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,590,684.51	320,827.89
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,590,684.51	320,827.89
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,055,000.00	900,000.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,055,000.00	900,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,055,000.00	900,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	3,055,000.00	900,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,055,000.00	900,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,055,000.00)	(900,000.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4417144353  
EHOA0056 9025707

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,663,567.79	57,336,088.80	735,109,232.65	836,108,889.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	* 00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,663,567.79	57,336,088.80	735,109,232.65	836,108,889.24
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,679,536.69	-6,679,536.69
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	778,772,800.44	57,336,088.80	-6,679,536.69	829,429,352.55
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	778,772,800.44	57,336,088.80	-6,679,536.69	829,429,352.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	57,336,088.80	57,336,088.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	778,772,800.44	57,336,088.80	50,656,552.11	886,765,441.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-57,336,088.80	00.00	-57,336,088.80
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	7,000,000.00	00.00	-13,071,888.88	-6,071,888.88
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	785,772,800.44	00.00	37,584,663.23	823,357,463.67

4417144353  
EHOAG056 9025707

Дорноговь аймгийн Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,677,400.00	191,677,400.00	-	100.00
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	191,677,400.00	191,677,400.00	-	100.00
4	Бараа, үйлчилгээний зардал	181,514,000.00	181,193,172.11	320,827.89	99.82
5	Цалин хөдө болон нэмэгдэл урамшил	103,659,900.00	103,643,276.52	16,623.48	99.98
6	Үндсэн цалин	91,031,700.00	91,015,076.85	16,623.15	99.98
7	Нэмэгдэл	5,098,200.00	5,098,199.67	0.33	100.00
9	Урамшуулал	7,530,000.00	7,530,000.00	-	100.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,935,200.00	11,935,199.59	0.41	100.00
12	Тэтгэврийн даатгал	7,956,900.00	8,053,099.59	(96,199.59)	101.21
13	Тэтгэмжийн даатгал	994,600.00	970,500.00	24,100.00	97.58
14	ҮОМШӨ ний даатгал	795,600.00	776,400.00	19,200.00	97.59
15	Ажилгүйдлийн даатгал	198,900.00	194,100.00	4,800.00	97.59
16	Эрүүл мэндийн даатгал	1,989,200.00	1,941,100.00	48,100.00	97.58
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,267,100.00	27,072,961.00	194,139.00	99.29
18	Гэрэл хангалгаан	2,482,200.00	2,247,952.00	234,248.00	90.56
19	Түлш, халаалт	21,960,900.00	21,960,900.00	-	100.00
20	Цэвэр, бохир ус	2,824,000.00	2,864,109.00	(40,109.00)	101.42
22	Хангамж, бараа материалын зардал	2,086,300.00	1,987,670.00	98,630.00	95.27
23	Бичиг хэрэг	318,200.00	318,200.00	-	100.00
24	Тээвэр (шатахуун)	530,000.00	528,930.00	1,070.00	99.80
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	148,100.00	114,080.00	34,020.00	77.03
26	Ном, хэвлэл	190,000.00	130,000.00	60,000.00	68.42
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	900,000.00	896,460.00	3,540.00	99.61
30	Норматив зардал	28,591,000.00	28,586,175.00	4,825.00	99.98
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	48,200.00	48,200.00	-	100.00
32	Хөөл, хүнс	26,222,800.00	26,221,975.00	825.00	100.00
33	Нормын хувиас зөвлөн эдлэл	2,320,000.00	2,316,000.00	4,000.00	99.83
34	Эд хогшил худалдан авах	5,740,000.00	5,736,180.00	3,820.00	99.93
38	Урсгал засвар	5,740,000.00	5,736,180.00	3,820.00	99.93
39	Томилголт, зочны зардал	150,000.00	150,000.00	-	100.00
41	Дотоод албан томилголт	150,000.00	150,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	483,500.00	482,540.00	960.00	99.80
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	483,500.00	482,540.00	960.00	99.80
53	Бараа үйлчилгээний бусад зардал	1,601,000.00	1,599,170.00	1,830.00	99.89
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,601,000.00	1,599,170.00	1,830.00	99.89
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,163,400.00	10,484,227.89	(320,827.89)	103.16
67	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	320,827.89	(320,827.89)	-
68	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	320,827.89	(320,827.89)	-
70	Бусад урсгал шилжүүлэг	10,163,400.00	10,163,400.00	-	100.00
77	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	10,163,400.00	10,163,400.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	191,677,400.00	191,677,400.00	-	100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	191,677,400.00	191,677,400.00	-	100.00
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	191,677,400.00	191,677,400.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО (жилийн дунджаар)	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

4417144353  
EIOA0056 9025707